

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТУЗ-ийн ердийн хоёр гишүүнийг
үүрэг ажлаас нь чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 77-р зүйлийн 77.5 болон 77.6 дах заалтууд, Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 8-р зүйлийн 8.10 дах заалт болон 2025 оны 10 сарын 15-ны өдрийн компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. ТУЗ-ийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг үндэслэн Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны саналын дагуу Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүн О.Ганжолоо болон Н.Мэндбаяр нарыг 2025 оны 10 сарын 15-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дүгнэлтийг үндэслэн ТУЗ-ийн ердийн гишүүн О.Ганжолоог үүрэгт ажлаас нь чөлөөлж түүний оронд ТУЗ-ийн ердийн гишүүнээр John Spence-г 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл томилсугай.
3. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дүгнэлтийг үндэслэн ТУЗ-ийн ердийн гишүүн Н.Мэндбаярыг үүрэгт ажлаас нь чөлөөлж түүний оронд ТУЗ-ийн ердийн гишүүнээр Thomas Holland-г 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл томилсугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Компанийн Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшинд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ